

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 07 дугаар сарын 02

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Бор-Өндөр УБҮ-т “Дархан чиглэлийн цэвэр ус хангамжийн 35 кВ-ын ЦДАШ-ыг шинэчлэх зураг, төсөв боловсруулж батлуулах” зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх тухай саналаа цахимаар ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд:

- Бор-Өндөр хотын ус хангамжийн 35/0.4 кВ-ын 2х400 кВА хоёр дэд станцыг, ашиглалтын хугацаа дууссан 35 кВ-ын модон тулгуур бүхий “Дархан” ЦДАШ-с 110 кВ-ын “Хэнтий” ЦДАШ-д хүчдэлийн түвшинг өсгөж шилжүүлэн холбох, шинэчлэх ажлын ТЭЗҮ боловсруулна.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээ эх хувиар /хуулбар бол нотариатаар баталгаажуулна/
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ эх хувиар /хуулбар бол нотариатаар баталгаажуулна/
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ
- Сүүлийн 3 жилийн (2018-2021) хугацаанд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээ болон гэрээ дүгнэсэн акт эх хувиар, /хуулбар бол нотариатаар баталгаажуулна/
- Санхүүгийн аудитлагдсан тайлан ирүүлэх жилийн тоо: 2019, 2020 он

4. Тендерийн хэл нь Монгол хэл байна.

5. Сонирхсон этгээд тодруулга мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө ажлын өдрийн 09:00 -14:00 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 09:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот-51, ш/х-002

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо,

“Монголросцветмет” ТӨҮГ-ын өөрийн байр, өрөө: 302

И-мэйл: amgalanbayar@monros.mn

Утас: 450060-255